

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН САНГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлж, дотоодын төсөлд санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар хөрөнгийг арвижуулах, хөгжлийн санг байгуулах, сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгийг удирдах, хуваарилах, хөгжлийн сангийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хөгжлийн сангийн тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хөгжлийн сантай холбогдсон харилцааг энэ хуулиар нийтлэг харилцааг Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиар зохицуулна.

3.2.Хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“Хөгжлийн сангийн хөрөнгө” гэж Хөгжлийн сангийн эзэмшил, өмчлөлд байгаа эдийн болон эдийн бус бүх хөрөнгийг;

4.1.2.“хөрөнгийн удирдлагын мандат” /цаашид “мандат” гэх/ гэж хөрөнгө оруулалт хийх зорилгоор эрх бүхий этгээдээс баталсан Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон баримт бичгийг;

4.1.3.“хөрөнгө оруулалтын стратеги” гэж мандатын хүрээнд Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд баримтлах стратегийн баримт бичгийг;

4.1.4.“Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын орлого” гэж Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагын үр дүнд бий болсон хүү, ногдол ашиг, хувьцаа худалдсан, арилжаалсаны ашиг зэрэг Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг;

4.1.5.“ашиг сонирхлын зөрчил” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.3-т заасныг;

4.1.6.“ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.11-д заасныг.

5 дугаар зүйл.Хөгжлийн сангийн эрх зүйн байдал

5.1.Хөгжлийн сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс өөрт ногдсон хэсгийг хуримтлуулж, дотоодын төсөлд, санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийж, өөрийн хөрөнгийг арвижуулах зорилго бүхий ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

5.4.Хөгжлийн сан нь өөрийн хөрөнгө оруулсан хуулийн этгээдээс хараат бус байх бөгөөд хариуцлага хүлээхгүй.

5.5.Хөгжлийн сан нь энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг хариуцсан болон эрсдэлийн удирдлага, дотоод аудит, захиргааны асуудал хариуцсан үндсэн нэгжтэй байна.

5.6.Энэ хуулийн 5.5-д заасан Хөгжлийн сангийн нэгжийн чиг үүргийг Хөгжлийн сангийн дүрмээр тогтооно.

6 дугаар зүйл.Хөгжлийн сангийн өөрийн хөрөнгө

6.1.Хөгжлийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг хувьцаа эзэмшигч тогтооно.

6.2.Хөгжлийн сангийн өөрийн хөрөнгийг хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр нэмэгдүүлж болно.

7 дугаар зүйл.Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

7.1.Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 7.1.1.хараат бус, бие даасан байх;
- 7.1.2.ил тод, нээлттэй байх;
- 7.1.3.Хөгжлийн сангийн хөрөнгийг зохистой удирдах;
- 7.1.4.Хөгжлийн сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах;
- 7.1.5.хариуцлагатай байх.

8 дугаар зүйл.Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг хэрэгжүүлэх

8.1.Энэ хуулийн 7.1.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

8.1.1.Хөгжлийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд **төрийн байгууллага, албан тушаалтнаас** нөлөөлөхгүй, зааварчилгаа өгөхгүй байх;

8.1.2.энэ хуульд зааснаар сонгон шалгаруулах, томилох, гэрээ байгуулах ажиллагааг зохион байгуулахад **төрийн байгууллага, албан тушаалтнаас** аливаа хэлбэрээр нөлөөлөхгүй байх;

8.1.3.Хөгжлийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, энэ хуульд зааснаар сонгон шалгаруулах, томилох, гэрээ байгуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд бусдын нөлөөнд автахгүй, хараат бус, бие даасан байх;

8.1.4.төлөөлөн удирдах зөвлөл, Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцогч этгээд, Хөгжлийн сангийн эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага, ажилтан ашиг сонирхлын зөрчилтэй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсч болох шийдвэр гаргахгүй, үйл ажиллагаа явуулахгүй байх;

8.1.5.Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагыг өрсөлдөхүйц цалин хөлсөөр хангах.

8.2.Энэ хуулийн 7.1.2-т заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

8.2.1.Хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг олон нийтэд энэ хуульд заасан журмын дагуу ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлж байх;

8.2.2.энэ хуульд олон нийтэд мэдээлэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлэх.

8.3.Энэ хуулийн 7.1.3-т заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

8.3.1.Хөгжлийн сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хадгалах, түүнийг арвижуулах;

8.3.2.хөрөнгө оруулах шийдвэр нь тооцоо, судалгаанд суурилсан үндэслэлтэй байх;

8.3.3.эрсдэлийг хэт төвлөрүүлэхгүй байх;

8.3.4.эрсдэлийг зохистой удирдах бүтэц, арга, хэрэгсэлтэй байх;

8.3.5.сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах хуулийн этгээдийн хүлээсэн төлбөрийн үүргийг сангийн хөрөнгөөр хүлээхгүй байх;

8.3.6.үндэсний баялгийн сангийн олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг баримтлах.

8.4.Энэ хуулийн 7.1.4-т заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

8.4.1.Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ мандатад заасан өгөөжийн зорилтот түвшинг хангаж ажиллах;

8.4.2.Хөгжлийн сангийн хөрөнгийг урт хугацаанд өгөөжтэй байхаар удирдах.

8.5.Энэ хуулийн 7.1.5-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

8.5.1.Хөгжлийн сангийн мандат, стратегийг мөрдөж ажиллах;

8.5.2.Хөгжлийн сангийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн байх;

8.5.3.энэ хууль болон бусад хуульд заасан тайлан, дүгнэлт, шийдвэр, зөвлөмжийг хуульд заасан хугацаанд гаргах;

8.5.4.хөрөнгө оруулалтыг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу хийх;

8.5.5.Хөгжлийн сангийн нэр хүндэд харш аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

8.5.6.Хөгжлийн сангийн хөрөнгийг улс төрийн үйл ажиллагаа явуулах болон санхүүжүүлэхэд ашиглахгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗАРЦУУЛАЛТ, ХУВААРИЛАЛТ

9 дүгээр зүйл.Хөгжлийн сангийн эх үүсвэр

9.1.Хөгжлийн сангийн орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

9.1.1.Засгийн газраас Хөгжлийн сангийн эзэмшилд шилжүүлсэн хөрөнгө;

9.1.2.Хөгжлийн сангийн хөрөнгөд бүртгэлтэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

9.1.3.Хөгжлийн сангийн хөрөнгөд бүртгэлтэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчид хамаарах хувьцааг борлуулсны орлого;

9.1.4.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас олох ашиг;

9.1.5.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээдийг өөрчлөн байгуулсаны үндсэн дээр бий болсон ашиг.

10 дугаар зүйл.Хөгжлийн сангийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх

10.1.Хөгжлийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал, энэ хуульд заасан хөндлөнгийн аудит, хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниас үйлчилгээ авсны зардлыг Хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан зардлын тухайн жилд зарцуулах дээд хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн өмнөх гурван жилийн дунджийг үндэслэн Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл батална.

10.3.Хөгжлийн сангийн эх үүсвэр, хөрөнгөөс энэ хуулийн 10.1-д зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно.

11 дүгээр зүйл.Хөгжлийн сангийн ногдол ашиг хуваарилах

11.1.Хөгжлийн сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргана.

11.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

11.3.Хөгжлийн сангийн татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашгийг Ирээдүйн өв санд хуримтлуулах зорилгоор шилжүүлнэ.

11.4.Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

12 дугаар зүйл.Хөрөнгийн удирдлагын мандат

12.1.Мандатыг Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хурал батална.

12.2.Мандатын хэрэгжилтэд хувьцаа эзэмшигчдийн хурал хяналт тавина.

12.3.Мандатад дараах мэдээллийг тусгана:

12.3.1.хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, хөгжлийн сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо;

12.3.2.хөрөнгө оруулалт хийх төслийн төрөл, хязгаарлалт;
12.3.3.энэ хуулийн 12.3.2-т заасан төсөлд хөрөнгө оруулсантай холбогдон үүсч болох эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын арга, хэрэгслийн тухай;

12.3.4.хөгжлийн сангийн активын бүтцэд тавигдах шаардлага;

12.4.Гүйцэтгэх удирдлага нь мандатын хэрэгжилтийн талаар төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана.

12.5.Мандат зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн тухай бүр гүйцэтгэх удирдлага нь түүний тайлбар, авах арга хэмжээний саналыг тусган сангийн төлөөлөн удирдах зөвлөлд ажлын гурван өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

12.6.Төлөөлөн удирдах зөвлөл нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор мандат зөрчигдсөн нөхцөл, байдлыг шийдвэрлэх арга хэмжээний чиглэл өгч, биелэлтийг хангуулна.

13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын стратеги

13.1.Гүйцэтгэх удирдлага хөрөнгө оруулалтын стратегийн төслийг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж батлуулна.

13.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай тохиолдолд мандатад нийцүүлэн хөрөнгө оруулалтын стратегид өөрчлөлт оруулж, шинэчилнэ.

13.3.Хөрөнгө оруулалтын стратегийг шинэчлэн баталсан, өөрчлөлт оруулсан тухай бүр төлөөлөн удирдах зөвлөл даруй хувьцаа эзэмшигдийн хуралд хүргүүлнэ.

13.4.Хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтийг улирал бүр төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, дүгнэлт гаргана.

13.5.Төлөөлөн удирдах зөвлөл хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих үүрэгтэй.

13.6.Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн сангийн санхүүгийн болон үйл ажиллгааны тайланд үндэслэн хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтийн жилийн тайланг гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлнэ.

13.7.Энэ хуулийн 13.6-д заасан тайланг төлөөлөн удирдах зөвлөл хүлээн авч нэг сарын дотор дүгнэлт гаргана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН САНГИЙН УДИРДЛАГА

14 дүгээр зүйл.Хөгжлийн сангийн хувьцаа эзэмшигч

14.1.Засгийн газар Хөгжлийн сангийн хувьцаа эзэмшигч байна.

14.2.Хөгжлийн сангийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний чөлөөт цагт төлөөлөн удирдах зөвлөл байна.

14.3.Хөгжлийн сангийн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална.

14.4.Хөгжлийн сангийн болон хөрөнгө оруулсан охин компанийн ногдол ашгийн бодлогыг хувьцаа эзэмшигч батална.

15 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл

15.1.Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл есөн хараат бус гишүүнтэй байна.

15.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг олон улсад нээлттэй сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар гурван жилийн хугацаагаар томилж, Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

15.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хоёроос дээш удаа улируулан томилохгүй.

15.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар томилно.

15.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь Компанийн тухай хуулийн 79.1-д зааснаас гадна дараах шалгуурыг хангасан байна:

15.5.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

15.5.2.ял шийтгэлгүй байх;

15.5.3.эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон бол тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй болох нь нотлогдсон байх;

15.5.4.хөрөнгө оруулсан этгээдийн эрх бүхий албан тушаалтан бус байх;

15.5.5.хөрөнгийн болон санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ захиргааны хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.

15.5.6.сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал хашиж байгаагүй байх;

15.5.7.улс төрийн намын гишүүн биш байх, гишүүнчлэлтэй бол түдгэлзүүлсэн байх;

15.5.8.Хөгжлийн сангийн эрх бүхий албан тушаалтантай хамаарал бүхий этгээд бус байх;

15.5.9.санхүү, эдийн засаг, хууль, уул уурхай, дэд бүтэц, хүнд үйлдвэрлэлийн аль нэг чиглэлээр дээд боловсролтой байх;

15.5.10.энэ хуулийн 15.5.9-д заасан салбарт арваас доошгүй жил ажилласан байх бөгөөд үүнээс таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх.

15.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.

15.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг үүргийг хавсран эрхлэхийг хориглоно.

16 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

16.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.Хөгжлийн сангийн мандатын хүрээнд хөрөнгө оруулалтын стратеги батлах;

16.1.2.үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг батлах;

16.1.3.Хөгжлийн сангийн гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журам батлах, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг үнэлэх;

16.1.4.Хөгжлийн сангийн эрсдэлийн удирдлагын бодлого батлах;

16.1.5.Хөгжлийн сангийн зохион байгуулалтын бүтэц, жилийн төсөв, орон тооны дээд хязгаарыг батлах;

16.1.6.Хөгжлийн сангийн бүтцийн нэгжийн ажиллах журмыг батлах;

16.1.7.хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын санал хүргүүлэх;

16.1.8.ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэх;

16.1.9.хувьцаа эзэмшигчид жил бүр ажлаа тайлагнах;

16.1.10.Хөгжлийн сангийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэх;

16.1.11.Хөгжлийн сангийн дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулах;

16.1.12.хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани болон хөндлөнгийн аудитын байгууллагыг олон улсад нээлттэй сонгон шалгаруулах, гэрээ байгуулах;

16.1.13.гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг батлах;

16.1.14.Хөгжлийн сангийн ёс зүйн дүрмийг батлах;

16.1.15.хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн засаглал, удирдлагыг хэрэгжүүлэх бүтцийг тогтоох;

16.1.16.хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх удирдлагын багийг томилох, чөлөөлөх;

16.1.17.хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хяналт тавих;

16.1.18.хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

16.1.19.хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх удирдлагын багийн цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

16.1.20.энэ хууль болон хөгжлийн сангийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

16.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэгт Компанийн тухай хуулийн 76.1.2-76.1.5-д заасан бүрэн эрх хамаарахгүй.

16.3.Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн болон дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмыг тогтооно.

17 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан

17.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь байнгын ажиллагаатай байх бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

17.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан ээлжит болон ээлжит бус байна.

17.3.Төлөөлөн удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа ээлжит хуралдааныг хуралдуулна.

17.4.Төлөөлөн удирдах зөвлөл шаардлагатай гэж үзсэн асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга эсхүл гурваас доошгүй гишүүдийн саналаар ээлжит бус хуралдааныг тухай бүр хуралдуулна.

17.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи биечлэн эсвэл цахимаар оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

17.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

17.7.Төлөөлөн удирдах зөвлөл хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

17.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

17.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааны явцыг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд түүнд хуралдаанд оролцсон гишүүд, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааны явцыг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, мэдээллийн бусад техник хэрэгсэл ашиглан баримтжуулж болно.

17.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар ашиг сонирхлын зөрчилтэй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц асуудлыг хэлэлцэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хуралдаан эхлэхээс өмнө энэ тухай мэдэгдэж, уг асуудлыг хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцохгүй.

17.11.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд гаргасан саналынхаа төлөө Компанийн тухай хуулийн 84.8, 84.9, 85 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

18 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо

18.1.Төлөөлөн удирдах зөвлөл дараах хороотой байна:

- 18.1.1.аудитын;
- 18.1.2.хөрөнгө оруулалтын;
- 18.1.3.эрсдэлийн.

18.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хоёр хүртэл хороонд ажиллаж болно.

18.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын болон эрсдэлийн хороонд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн давхардуулан орж болохгүй.

18.4.Хороодын даргыг хороодын гишүүдийн олонхийн саналаар гурван жилийн хугацаагаар сонгоно.

18.5.Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд энэ хуулийн 18.1-д зааснаас бусад хороог байгуулж, тэдгээрийн эрх, үүргийг тогтоож болно.

19 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

19.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар дараах шаардлагыг хангасан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно:

19.1.1.Монгол Улсын иргэн байх;
19.1.2.ял шийтгэлгүй байх;
19.1.3.эдийн засаг, санхүү, үнэт цаас, хууль зүйн аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх;

19.1.4.хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх.

19.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ:

19.2.1.төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хадгалах;

19.2.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд мэдээлэл хүргэх;

19.2.3.төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;

19.2.4.төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх;

19.2.5.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;

19.2.6.төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах.

19.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилон ажиллуулна.

20 дугаар зүйл.Хөгжлийн сангийн гүйцэтгэх удирдлага

20.1.Хөгжлийн сангийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн, эсхүл багаар хэрэгжүүлнэ.

20.2.Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн, эсхүл багаар хэрэгжүүлэх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

20.3.Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх хувь хүн эсхүл багийн гишүүн нь энэ хуулийн 17.5-д заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

20.3.1.санхүү, хөрөнгө оруулах үйл ажиллагаанд шийдвэр гаргах түвшинд арваас доошгүй жил, үүнээс санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;

20.3.2.ял шийтгэлгүй, ёс зүй болон бизнесийн нэр хүнд нь Хөгжлийн санг удирдахад харшлахгүй байх;

20.3.3.улс төрийн албан тушаалтан биш байх;

20.3.4.төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон бусад шаардлага.

20.4.Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн сангийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

20.5.Гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

20.6.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Хөгжлийн санг төлөөлөх зэргээр Хөгжлийн сангийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

20.7.Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх тохиолдолд Хөгжлийн сангийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

20.8.Энэ хуулийн 20.7-д заасан баг төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө гэрээ болон Хөгжлийн сангийн дүрэм, холбогдох хууль тогтоомжийн дагуу хамтын хариуцлага хүлээнэ.

20.9.Гүйцэтгэх удирдлага энэ хуулийн 20.6-д заасны дагуу гэрээ, хэлцэл хийх, төлөөллийг хэрэгжүүлэх тохиолдолд Хөгжлийн санг төлөөлж багийн ахлагч гарын үсэг зурна.

20.10.Энэ хуулийн 20.9-д заасан багийн ахлагчийг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн багийн гишүүд сонгох бөгөөд багийн ахлагч Хөгжлийн сангийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэнэ.

20.11.Гүйцэтгэх удирдлагын багийн хуралдаанд багийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

20.12.Гүйцэтгэх удирдлагын багийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

20.13.Гүйцэтгэх удирдлагын багийн хурал, гаргасан шийдвэрийн тэмдэглэлийг заавал хөтлөх бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал биечлэн хариуцна.

20.14.Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл хэдийд ч гаргах эрхтэй.

20.15.Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд Хөгжлийн сангийн гүйцэтгэх захирал байна.

20.16.Гүйцэтгэх удирдлага дараах үндсэн бүрэн эрхтэй:

20.16.1.хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;

20.16.2.Хөгжлийн сангийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Хөгжлийн санг төлөөлөх;

20.16.3.Хөгжлийн сангийн жилийн төсвийг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг зохион байгуулах;

20.16.4.Хөгжлийн сангийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах;

20.16.5.төлөөлөн удирдах зөвлөлөөс олгогдсон эрх хэмжээний хүрээнд, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээнд хамруулснаас бусад журам, заавар, аргачлалыг батлах;

20.16.6.хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;

20.16.7.мандат, хөрөнгө оруулалтын стратегийн дагуу Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, үр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

20.16.8.Хөгжлийн сангийн дотоод нэгжүүд болон хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны уялдааг хангах;

20.16.9.Хөгжлийн сангийн өмнө бусад этгээдийн хүлээсэн үүргийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

20.16.10.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг тухай бүр гаргаж тэдгээрийн үнэн зөв байдлыг хариуцах;

20.16.11.төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө ажлаа улирал бүр тайлагнах;

20.16.12.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан Хөгжлийн сангийн ил тод байдлыг ханган ажиллах;

20.16.13.Хөгжлийн сангийн ёс зүйн дүрмийг баримтлах;

20.16.14.Хөгжлийн сангийн дүрэмд заасан тодорхой бүрэн эрх.

20.17.Гүйцэтгэх удирдлага нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлч ажил эрхлэхээс бусад ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглоно.

20.18.Гүйцэтгэх удирдлага ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчтэй байх зэрэг тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлөөс урьдчилан тогтоосон этгээдэд өөрийн бүрэн эрхийг тушаалаар шилжүүлж болох бөгөөд ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

20.19.Гүйцэтгэх удирдлага хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн нь эрх бүхий этгээд, хөндлөнгийн хяналтын байгууллагаас тогтоогдсон тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээг цуцалж болно.

21 дүгээр зүйл.Хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани

21.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг гэрээний үндсэн дээр хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гүйцэтгүүлж болно.

21.2.Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл энэ хуулийн 21.1-д заасан хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулах журмыг батална.

21.3.Энэ хуулийн 21.1-д заасан хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани болон Хөгжлийн сангийн хооронд байгуулах гэрээг төлөөлөн удирдах зөвлөл байгуулна.

21.4.Энэ хуулийн 21.3-т заасан гэрээнд хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

22 дугаар зүйл.Хөгжлийн сангийн үйл ажиллагаа

22.1.Хөгжлийн сан дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

22.1.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан төсөлд хөрөнгө оруулалт хийх;

22.1.2.хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, өрсөлдөх чадвар, зах зээлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх.

23 дугаар зүйл.Хөгжлийн санд хориглох үйл ажиллагаа

23.1.Хөгжлийн сан дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

23.1.1.зээл авах;

23.1.2.Хөгжлийн сангийн хөрөнгийг барьцаалах, зээл олгох, зээлийн баталгаа, батлан даалт гаргах болон бусад аливаа хэлбэрээр бусдын үүргийн гүйцэтгэлийг хангах, гэрээ, хэлцэл байгуулах;

23.1.3.санхүүгийн хөшүүрэг оролцсон аливаа төрлийн гэрээ, хэлцэл хийх;

23.1.4.үүсмэл санхүүгийн хэрэгслийг зөвхөн хөрөнгө оруулалтын эрсдэлийг хаах, бууруулахаас бусад зорилгоор ашиглах;

23.1.5.төсвийн алдагдлыг нөхөх болон улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;

23.1.6.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт хийгээгүй төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зардал, алдагдлыг санхүүжүүлэх;

23.1.7.нийгмийн халамжийн чиглэлээр санхүүжилт хийх;

23.1.8.улс төрийн нам, эвсэлд хандив өгөх.

24 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалт хийх

24.1.Хөгжлийн сан дараах шаардлагыг хангасан төсөлд хөрөнгө оруулалт хийнэ:

24.1.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан байх;

24.1.2.мандат, хөрөнгө оруулалтын стратегийн чиглэлд нийцсэн санхүүгийн үр өгөөжтэй төсөл байх;

24.1.3.техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн байх;

24.1.4.энэ хуулийн 25.1.3-д заасан техник, эдийн засгийн үндэслэлд дурдсан эдийн засгийн болон санхүүгийн үр өгөөж нь мандатад тодорхойлсон зорилтот үр өгөөжийг хангахуйц байх;

24.1.5.төслийн эрсдэлийн үнэлгээ, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр нөлөөг зохих аргачлалын дагуу тооцсон байх;

24.1.6.Монгол Улсын нутагт дэвсгэрт хэрэгжих.

25 дугаар зүйл.Хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, өрсөлдөх чадвар, зах зээлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх

25.1.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулсан хуулийн этгээд нь сайн засаглалын зарчмыг дагаж мөрдөнө.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан сайн засаглалын зарчмыг Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

25.3.Хөгжлийн сан хөрөнгө оруулсан хуулийн этгээддээ инновац, шинэ технологи, олон улсын стандарт нэвтрүүлж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ТАЙЛАГНАЛ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ

26 дугаар зүйл.Хөгжлийн сангийн тайлан

26.1.Хөгжлийн сан санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал, бүтэн жилээр гаргана.

26.2.Хөгжлийн сангийн улирлын тайланд дараах зүйлийг тусгана:

26.2.1.Хөгжлийн сангийн санхүүгийн тайлан;

26.2.2.Хөгжлийн сангийн төсвийн орлого, зардлын гүйцэтгэл;

26.2.3.Хөгжлийн сангийн үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл.

26.3.Хөгжлийн сангийн жилийн тайланд дараах зүйлийг тусгана:

26.3.1.энэ хуулийн 26.2-т заасан улирлын тайланд тусгасан зүйлс;

26.3.2.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилт;

26.3.3.Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын багцын бүтэц, үнэлгээ тайлант үеийн туршид хэрхэн өөрчлөгдсөн талаарх болон өгөөжийн үзүүлэлтүүдийг тусгасан дэлгэрэнгүй тайлан;

26.3.4.Хөгжлийн сангийн эрсдэлийн удирдлагын тайлан;

26.3.5.аудитын дүгнэлт.

26.4.Хөгжлийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлнэ.

26.5.Гүйцэтгэх удирдлага Хөгжлийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлнэ.

26.6.Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор дүгнэлт гаргаж, аудитын дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

27 дугаар зүйл.Хөгжлийн сангийн ил тод байдал

27.1.Хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой дараах мэдээллийг Хөгжлийн сангийн гүйцэтгэх удирдлага олон нийтэд мэдээлнэ:

27.1.1.Хөгжлийн сангийн асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийг албан ёсоор нийтэлснээс хойш 10 хоногийн дотор;

27.1.2.Хөгжлийн сангийн мандат болон хөрөнгө оруулалтын стратегийг батлагдсанаас хойш 10 хоногийн дотор;

27.1.3.Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор;

27.1.4.Хөгжлийн сангийн санхүүгийн жилийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг уг дүгнэлтийг гаргаснаас хойш 10 хоногийн дотор;

27.1.5.Хөгжлийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргаснаас хойш 10 хоногийн дотор;

27.1.6.Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг шийдвэр гаргаснаас хойш 10 хоногийн дотор;

27.1.7.хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани, хөндлөнгийн аудит болон мэргэжлийн бусад оролцогчийн нэрийг нээлттэй сонгон шалгаруулсанаас хойш 10 хоногийн дотор;

27.1.8.хуульд заасан бусад.

27.2.Энэ хуулийн 27.1 дэх хэсэг нь Хөгжлийн сангийн хөрөнгө оруулсан хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

27.3.Хөгжлийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн хэлбэр, тайланд тавих тусгай шаардлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28 дугаар зүйл.Хөндлөнгийн аудит

28.1.Хөгжлийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд олон улсын нэр хүнд бүхий хөндлөнгийн аудитын байгууллагаар доор дурдсан журмаар аудит хийлгэнэ:

28.1.1.хоёр жилд нэгээс доошгүй удаа;

28.1.2.хувьцаа эзэмшигч Хөгжлийн сангийн мандатын хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэсэн тухай бүр.

28.2.Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл энэ хуулийн 29.1-д заасан аудитын байгууллагыг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгож, гэрээ байгуулан ажиллуулна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

29 дүгээр зүйл.Хариуцлага хүлээлгэх үндэслэл

29.1.Хөгжлийн сангийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан хариуцлага оногдуулсан нь түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

30 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

30.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

30.2.Хөгжлийн сангийн тухай хууль зөрчигчид торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

31 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

31.1.Энэ хуулийг Үндэсний баялгийн сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР